



THE WORLD OF THE LOTUS SUTRA

Цагаан Лянхуа Цэцгийн Судар

Зөгнөлийн үг авсан таван зуун шавь, 8-р бүлэг (Part 2)

“Нэгэн ядуу хүн найздаа найдаж гэрт нь очжээ.Найз нь ч хоол ундаар сайн дайлж,илгэмсэгээр хүлээн авсан тул тэр хүн ч бүр согтоод унтчихсан юм.Гэтэл найз нь гадагшаа явах яаралтай ажил гарсан тул түүнийг сэрээгээд яахав гээд найзынхаа дээлнийх нь дотор талд нь хэмжиж барашгүй үнэтэй эрдэнэт чулуу оёж өгөөд явсан юм.Нөгөөх хүн ч удалгүй сэрээд найзыгаа мөд эргэж ирэхгүйг мэдээд гараад явжээ.Бас л ядуучилж,эцэст нь бүр гуйлгачин болов.Хоол хүнсээ олох гэж ядран,хааяа олж ирсэн орлогондоо сэтгэл хангалуун байдаг байв.Нилээн цаг хугацааны дараа тэр нөгөө найзтайгаа зам дээр тааралддаг байна.Найз нь түүний ядуу байдлыг хараад.”Ямар тэнэг юм бэ,би чиний төлөө дээлэнд чинь үнэтэй чулуу оёж орхисон байсан шүү дээ” гээд алмайран зогсох ядуу найзынхаа дээлний хормойноос нь нөгөөх чулуугаа гаргаж ирээд.”За,одоо үүнийг зараад дуртай юмаа худалдан авч,юугаар ч дутагдахгүй амьдар” гэжээ.

Тэд энэхүү яриагаа дуусмагц:”Шагжамүни та ч мөн энэхүү найзтай адил.Та биднийг бодисадва байхад “Хүн бүрт бурханлаг чанар байдаг.Даяанаа хийгээд байвал

Буддагийн гэгээрэлд хүрнэ” гэж заадаг байсан.Гэвч бид болохоор зөвхөн сэтгэлийнхээ тээнэгэлзлийг л авч хаявал болно гэж боддог байлаа.Тиймээс ч сэтгэл маань нэг л дутмаг байсан юм.Одоо та бидний нүдийг нээж,бодисадвагийн үйлдээ шамдаж,хүмүүсийн төлөө буянтай үйл үйлдэж байвал Буддагийн гэгээрэлд хүрнэ гэдгийг зааж өглөө.Ийм талархалтай зүйл гэж өөр байхгүй” гэж хэлээд толгойгоо бөхийн дахин талархав.



Нуруугаа тэгшил

Жил бүрийн хаврын улирал гэдэг нь сургуульд элсэх, төгсөх, ажилд орох, нүүдэл суудал гээд л нэг л орон гаран байдаг билээ.

Нааш цааш яаран сандрах хүнийг хараад өөрийн эрхгүй “та жаахан суугаад өгөөч” гэж хэлж орхидог. Яагаад гэвэл хүн “завгүй” гэсэн ханзын утгатай адил “сэтгэлээ алддаг” юм.

Эсрэгээр сэтгэл санаа тайван байвал бид амьдралаа амар сайхан өнгөрөөж чаддаг билээ. Тэгвэл хүн явал амар тайван сэтгэлтэй болж чадах вэ? гэдгийг бодоцгооё.

Үүнд юуны өмнө биеэ авч явах байдал, дүрс үзэмжээсээ сэтгэлээ тайвшруулах арга байдаг байна. Хүний бие сэтгэл нь гүн уялдаа холбоотой бөгөөд бие биендээ нөлөөтэй гэдэг билээ.

Сурган хүмүүжүүлэгч Мори Шинми багш “сэтгэлээ өөдрөг болгоё гэвэл нуруугаа тэгшил” гэдэг нь хүн нурууныхаа ясыг эгц болгосноор бие сэтгэлийн аль алин нь тэгширч засардаг гэдэгтэй холбоотой.

Бас Догэн зэн багш нь “биеэ засаж тэгшилснээр уравсан сэтгэл эргэж сэргэнэ” гэж хэлдэг байв. Өөрөөр хэлбэл, сэтгэл шантарсан үед юуны өмнө нуруугаа эгц болгон тэгшилснээр хүний сэтгэл бага багаар тайвширч амардаг байна.

Хүн сэтгэл мэдрэлээ хянаж, явал амгалан тайван байж чадахаа аль эрт дээр үеэс судалж ирсэн байна. Тиймээс ч өнөө үе хүртэл уламжлагдан ирсэн йога дасгал ба зэн урсгалыг харахад хүний биеэ авч явах байдал нь сэтгэл санааг тайвшруулахад шууд нөлөөтэй гэдэг нь харагддаг байна.



Жинхэнэ амар тайван

Одоо бид сэтгэл тайван бус, сандарч бухимдсан байдлыг хэрхэн даван туулахыг ярилцая. Амар тайван бус сэтгэлийн нэгэн шалтгаан нь өөрийгөө бусадтай харьцуулах явдал билээ. Үүнд миний байнгын хэлдэг зүйл бол хүний амьдрал гэдэг нь хичнээн нандин, талархалтай зүйл гэдгийг хүн бүр мэдрэх хэрэгтэй юм. Хүн өөрийгөө бусадтай зүйрлэн харьцуулах явдал бол ямар ч утгагүй билээ. Яагаад гэвэл бүгд түр зуурын л өнгөнд будагдаж байдаг ба тэрхүү будагийг нь хуулан арилгавал бүх хүмүүс нэгэн гаралтай, нэгэн Агуу Их Амийн үндэстэй гэдэг нь илрэх юм.

Эдо үеийн нэрт эрдэмтэн Сато нь хүн өөрийнхөө сэтгэлийн хүндэтгэн эрхэмлэж, сэтгэлээ амар байна уу үгүй юу гэдгээ байнга харж байх нь өөртөө итгэлтэй амьдрах нэгэн арга гэж хэлж байсан юм.

Суух гэдэг үгтэй холбоотой бидний нэгэн үйл байдаг билээ. Энэ нь өдөр бүр өглөө оройдоо гүнгэрвааныхаа дэргэд сууж судраа унших явдал билээ. Үүгээр дамжиж бид бие сэтгэлээ тайвшруулж чадна. Бас хоза дээр сангагийн нөхдүүдтэй хамт тойрон сууж сэтгэлээ хуваалцдаг билээ. Хоза бол сургаал дээр

үндэслэж зохиогддог учраас хүний сэтгэлийг тайвшруулах нэгэн том арга юм.


Гэвч үнэндээ өдөр болгон тийм завтай хүн цөөхөн байдаг байх. Тэрнээс илүү завгүйдээ нааш цааш үсэрч харайсан сэтгэл тайван бус хүн элбэг байх.

Тэгвэл тийм үед яавал сэтгэлээ тайвшруулж чадах вэ?

“Амьд ч гэсэн үхсэн юм шиг хийх ёстой зүйлээ хийвэл санааны дагуу болно” гэсэн утгатай дуу байдаг билээ. Энэ нь хүн ямар ч үед ч өөрийгөө умартан мартаж, сэтгэл шулуудан ажил хэрэг, гэр орныхоо ажилд шамдан зүтгэвэл жинхэнэ амар тайвныг олно гэсэн утга юм.

Шагжамүни нь сэтгэл санаагаа төвлөрүүлэн тайвшруулж чадсан учраас бид нарт сургаалаа айлдаж чадсан билээ. Бусад хүмүүс ч амгалан тайван сэтгэлтэй болоосой гэсэн хүслийг агуулсан манай сургаал нь бидний эхний алхамын хэмжүүр мөн. Олж чадсан амгалан тайван сэтгэлээ бусадтай хуваалцсанаар жинхэнэ амар тайванд хүрдэг байна.

“Косэй” 2012 оны 2 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч
Нивано Коошо багш

Ямар ч хүүхдийг эх нь хайрладаг

Амралтын өдрийн өглөө ванны өрөөний угаалтуурыг цэвэрлэж байхад хоёр охин маань хоорондоо юм ярингаа нүүрээ угаахаар ороод ирэв. "Өглөөний мэнд. Сэрэнгүүтээ юугаа тэгтлээ их сонирхож яриад байна аа?" гэж асуухад "Харин тийм ээ, манай ангийн нэг эрэгтэй хүүхэд ёстой муухай. Хүн гадаа тоглож байхад хүрж ирж хүн дайрчихаад уучлал ч гуйхгүй яваад өгчихдөг. Бас бөмбөгөөрөө хүн ончихоод юу ч хэлдэггүй шүү", "гадаа тоглох хүртэл айдас хүрээд байна"

"Тэгвэл манай ангийн нэг эрэгтэй хүүхэд хичээлийн дунд дандаа шуугиж байдаг юм. Багш чимээгүй бай гэж хэлсэн ч улам шуугиж гардаг", "бас хүний харандаа авч зээлчихээд хугалчихаад буцаадаг", "байнга ширээн дээрээсээ юмаа унагаадаг"

"эрэгтэй хүүхэд гэж ёстой муухай"

Би ч бас бага байхдаа ангид тийм сахилгагүй эрэгтэй хүүхэд хажууд байдаг байсан тул охидын айдасыг сайн ойлгож байв. Тиймээс ч "харин тийм, ёстой аймар юм аа", "тийм хүүхэд хажууд байвал хэцүү юм аа" гэж толгойгоо дохин охидын яриаг сонсож байв.

Тэгтэл нэг мэдэхэд яриа нь бүр дэврэн хальж "ер нь тэр муу үс нь хүртэл нээх хачин сэгсийчихээд л шал инээдэмтэй амьтан", "тэр эрэгтэй хүүхдийн царай нь нэх сонин", "зан нь ч гэсэн хачин зантай" гэх мэтчилэн яриа нь нэг л өөр урсгал уруу ороод эхлэв. Тэгээд ч би тэр хоёрт ингэж хэлэв: "Ээж нь нэг юм хэлье. Эрэгтэй хүүхэд та нарыг дайрч унагааж, шуугилдаж сахилгагүйтэх нь үнэхээр аймар гэж би бодож байна. Гэхдээ хүний үс зүс, зан чанарыг ийм тийм гэж гоочлох нь юу бол доо? Ээж нь ч мөн гадны хүн та нарыг сахилгагүйгэж үймүүлсэн гэж гомдолж ирвэл би тэр хүнд уурлахгүй. Хүүхдүүдээ зөв хүмүүжилж, засахыг хичээнэ. Гэвч хүн надад танай хүүхдүүд хачин царайтай, хачин үс гээгтэй эсвэл хачин зантай гэж хэлбэл ээж нь үнэхээр шанална. Би та

Нивано Коошо

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



нарыгаа дэлхийд хамгийн хөөрхөн гэж боддогтой адил аль ч хүүхдийн эцэг эх бас л тэгж боддог юм.”

Үүнийг сонсоод хоёр охин маань нүдэндээ нулимс бүлцэгнүүлэн намайг тэврэв.

“Хийж болохгүй юмыг хийдэг хүн байдаг” болохоос “болохгүй хүн” гэж байхгүй. Ямар ч хүн эхтэй байдаг тул эхийн хайрыг амссан хүн бусад хүмүүс ч мөн эхээсээ хайрлагдаж байдаг гэдгийг санаж явах хэрэгтэй. Охидтойгоо ийнхүү ярилцасанаас хойш би ч гэсэн цашид хүмүүстэй харьцахдаа үүнийг санаж байя гэж бодсон юм.

“Ээж ээ, бид танд хайртай”, “ээж нь ч та нартаа хайртай шүү. Миний охид дэлхийд хамгийн хөөрхөн охид шүү. Өглөөний дөнгөж сэрсэн халтар царай ч, сэгсийж боссон үс нь ч, хачин инээдэг зан нь ч та бүгдийн бүхий л зүйлд ээж нь хайртай шүү”,

”Пөөх, та тэгж боддог байсан юм уу?”

“За, хүүхдүүд ээ, нүүрээ угааж, хувцсаа өмсөөрэй”

“За, ээж ээ”

Өнөөдрийн нэгэн өдөр ийнхүү эхэлж байна.

“Байдаг л зүйл” хэмээх гайхамшиг

Найтоу-эйко
Нью-Йорк сүмийн

Энэ илтгэл 2011 оны 12-р сарын 9-нд Нью-Йорк сүмийн гишүүдийн нэгдсэн хурал дээр тавигдсан юм.

Илтгэл тавих үүрэг хүлээж авахдаа “Надад бусад гишүүд шиг гайхамшигт явдал тохиолдсон зүйл ямар байгаа биш” хэмээн тус үүргийг хүлээж авах эсэхтээ нэлээдгүй эргэлзлээ.

Гэвч нийгэмлэгийн маань гишүүд “Чиний төлөө шүү дээ” хэмээн араас минь дэмжиж өгсөний ачаар өнөөдөр энд илтгэл тавихаар болсон билээ.

За ингээд, Косей кайгийн сургаальд суралцсанаар надад тохиолдсон гайхамшигуудын талаар ярихаасаа өмнө өөрийнхөө өсвөр үеийн амьдрал болон Косей Кайтай хэрхэн учирсан тухайгаа товчхон тайлбарлая гэж бодож байна.

Намайг гурван нас хүрэхтэй үгүйтэй байхад манайх ам бүл дөрвүүлээ Фүкүшимагаас Токио руу нүүж ирсэн юм. Аав ээж хоёр маань хөлөө олохын тулд тэр даруйдаа ажил олж хийхгүй бол болохгүй байлаа. Токиод түшиглэх хамаатан, найдах танил байгаагүй тул балчир байсан намайг харж хандах газар цөхрөлтгүй хайв. Яслид өгөхөөр болж олон газраар орсон боловч бүгд л авахаас татгалзсан гэдэг. Арга тасарсан ээж маань хамгийн сүүлд очсон цэцэрлэгийн эрхлэгч Косей Кайгийн гишүүн байсан бөгөөд намайг яслид авахыг зөвшөөрсөн гэдэг. Тэр ачит багш ээжийг маань Косей Кайд гишүүнээр элсүүлсэн юм. Ээж маань нөгөө ертөнцрүү явах хүртэлээ түүнийг амьдралын маань ачтан хэмээн хүндэлдэг байлаа.

Аав, ээж хоёр маань өглөөнөөс орой хүртэл борви бохисхийлгүй ажилдаг байсан тул би бага сургуульд орох хүртэлээ эрхлэгчийн гэрт өссөн гэж хэлэхэд хилсдэхгүй. Судар хурах эрхлэгчийн дэргэд суугаад, судрын дуу сонсдог байснаа одоо ч гэсэн сайн санадаг юм.

Намайг бага сургуульд орох үед манайх өөр тийш

нүүсэн тул түүнээс хойш Косей Кайгийн үйл ажиллагаанд оролцож чадахааргүй болж орхив.

16 настай байхдаа ааваа гэж бодож байсан хүн төрсөн эцэг минь биш гэдгийг мэдэв. Түүнтэй зэрэгцээд ээж маань дахин өөр хүнтэй гэрлэхээр болж сэтгэл маань үгээр хэлшгүй хүнд шархалж ганцаардалыг мэдрэх болов.

Шинэ хойд эцэг маань надад эелдэг сайхан ханддаг байсан ч архи уухаараа надаас болж ээжтэй хэрэлдэх нь ихсэв. Тэр хоёрын хэрэлдэхийг харах тоолонд сэтгэл өвдөн, хүнд хэцүү санагдаж <<Хэрвээ төрсөн эцэг маань байсан бол надад хэрхэн хандах байсан бол>> гэж боддог байлаа.

25 нас хүрэх үедээ хойд эцэг ээж хоёрын хэрүүлийг харж тэвчилгүй японоос алс хол орших Америкын Нью-Йорк хотыг зорьсон юм.

Ээж маань санаа нь зовж үргэлж утсаар ярих бөгөөд ярих тоолондоо <<Нью-Йоркт Косей Кайгийн салбар байдаг юм. Мөргөлөөр очиж үзээч>> гэж гуйдаг байлаа. Яах ч аргагүй болсон би <<Сүм дээр нь очиж үзэгдсэн болохоос>> гэсэн сэтгэлээр хааяа нэг сүм рүү очдог болов.

Явж ирээд <<Өнөөдөр сүм дээр очоод ирсэн>> гэж ээжид утсаар мэдэгдэх тоолонд ээж маань их л баяртайгаар сонсдог байж билээ. Тэр үед ээж маань миний төлөө үнэхээр их санаа нь зовдог байж дээ гэдгийг одоо л мэдрдэг юм. Тухайн үед би орь ганц өөрийн хүчээр амьдарч байгаа юм шиг омогтой, шазруун нэгэн байлаа. Тийм ч болохоор сүм рүү очсон ч сурсан зүйлгүй цай л уухын төлөө очдог сүнс шиг гишүүн байлаа.

Тийм омголон шазруун зантай байсан би бээр 2005 онд ээжийгээ алдаж, 16 жил хамт амьдарсан нөхрөөсөө салж, амьдрахын утга учирьг ойлгохоо

болив. Тэр үед сүмийн гишүүд намайг эелдэг, дулаахнаар түшиж, тулж өгсөн юм. Түүнээс хойш өөрийн нэрийг Эйко хэмээн өөрчилж өвөг дээдсийн хойтын буяны ном хурдаг болов. Тэр үед сүмийн тэргүүнээс <<Өдөр бүр судар хурж, бурхан багшид итгээрэй>> гэсэн удирдамж авсан юм.

Эргэлзэж, тээнэгэлзэх нь их байдаг би <<Судар унш. Бурхан багшид итгэ гэх юм. Судар хурж, Бурханд итгэлээ гээд нэмэр байгаа юм уу>> гэгчлэн хайхарсан шинжгүй байлаа. Тийм ч болохоор сургаалийг жинхэнэ утгаар нь ойлгоогүй байсан юм.

Нэгэн удаа намайг амрах завгүй ажиллаж, стрессэнд орчихоод байтал нийгэмлэгийн нэгэн гишүүн <<Эйко гуй, бурхан багшид итгээд бүгдийг түүнд даатгавал зүгээр. Хүн юу бодож сэтгэнэ, юу хэлж ярьж, юу хийнэ түүнийгээ л эргүүлж авдаг. Өөрөөр хэлбэл амьдралд тохиолдох сайн муу бүх зүйлийг хүн өөрөө л бий болгож байдаг юм шүү дээ>> гэж хэлэв.

Тэр үед <<Өмнө минь үүсэх элдэв явдалын эх үүсвэрийг би өөрөө л хийгээд байдаг байж магадгүй>> гэдгийг анх удаа бүдэг бадагхан ухаарсан мэт санагдав.

Улмаар <<Энэ сургаальд итгэж, хэрэгжүүлээд явбал бүх зүйл зүгээр байж магадгүй. Тиймээс эргэлзэж тээнэгэлзэлгүй хэлснийх нь дагуу хийгээд үзье>> гэж бодсон юм.

Тэгтэл сургаалийн үр дүн янз бүрээр илрэн гарч ирдэг болов. Тэдгээрийг ярьвал хэтэрхий их тул үг олдож үхэр холдоно гэгчээр маргааш орой хүртэл үргэлжилж магадгүй тул гурван зүйлийг онцлон авч ярьяа гэж бодож байна.

Эхнийх нь ажлын маань тухай юм. Би бээр өдгөө ачаа зөөж, айл өрх нүүлгэн шилжүүлдэг компанид ажилладаг. Ажлын захиалга авах чухал албан тушаал юм. Үнэхээрийн завгүй сар өдөрүүд үргэлжилж, дэвхцэх нь холгүй баярлаж байсан үеийн явдал юм.

Тэр сар үнэндээ бол ид бужигнасан завгүй сар болдог. Нүүлгэх асуудлаар хандаж утасдах хүмүүс олон боловч яагаад ч ажлын гэрээ байгуулж чадахгүй байлаа.

Би <<Саяхан харамч хүмүүс л утсаар ярих юм. Тэгтлээ их үнэ бууруулах юм бол манай компани үйлчлүүлэгч болж чадахгүй>> гэсэн байдалтай харьцаж байлаа.

Нэг өдөр хоозад өөрийнхөө ажлын нөхцөл байдлыг тайлбарлаж ярив. Тэр үед надад өгсөн удирдамж

<<Хүмүүс бүгдээрээ л арай жаахан хямдханаар нүүмээр байгаа юм байна шүү дээ>> гэсэн ганц үг байлаа. Тэр үед цочих шиг л болов. Өөрийн ашиг орлогын хойноос хөөцөлдөж, үйлчлүүлэгчийн сэтгэлийг үл тоомсорлосон өөрийгөө анзаарав. Түүнээс хойш харамч хэмээн бодож байсан үйлчлүүлэгч нарт <<Явал аль болох зардлаа хэмнэж хямдхан үнээр нүүх тал дээр зөвөлгөө өгч үзье>> гэж бодов. Ийнхүү сэтгэл минь өөрчлөгдсөн тэр өдрөөс хойш ажлын захиалга нэмэгдээд ирэв. Тэр үед өмнө маань үүссэн үзэгдэл юмсын шалтгаан нь яах аргагүй надад байдаг юм байна гэж үнэхээр бие сэтгэлээрээ мэдэрсэн юм.

Энэ явдлаар дамжуулж дээд хүнээсээ сургаальтай холбуулж удирдамж авахын чухалыг ойлгосон юм. Гав ганцаарханаа бодоод байвал өөрийн уйтхан туршлагын хүрэн дотор л юмс үзэгдэлийг олж харна. Удирдамж авсанаар бурхан багшийн билэг оюунаас хүртэж, улмаар өөрийн үзэл бодлыг өөрчилж чадна. Энэ бол үнэхээр гайхалтай гэж анх удаа үнэн голоосоо бодсон юм.

Дараагаар нь үерхэж байсан залуугаасаа хайр мэдэрхээ больсон тул сүм дээр очоод <<Эцэг эхээрээ ч олигтой хайрлуулж чадаагүй болохоор найз залуугаараа сэтгэлээ ханатал хайрлуулмаар байна>> хэмээн гомдол тоочив. Тэгтэл <<Эйко гуай өөрөө хүнд хайраа өгөхгүй болохоор хүнээс ч бас авч чадахгүй байгаа юм биш үү>> гэж хэлүүлэв. Тэр үед үнэхээр л тийм гэж бодсон.

Бусдаас авахаас өөрийг боддоггүй өөрийгөө анзаарав.

Тэр орой өөд болсон ээж маань зүүдэнд орж ирэв. Би шүршүүрт ороод зогсож байх юм. Миний ард ээж маань даарчихсан чичрээд зогсож байв. Би <<Ээжээ хүйтэн байгаа биз дээ. Та ч гэсэн халуун шүршүүрт ороод ир>> гэж хэлтэл ээж <<Чи эхлээд ордоо. Ээж нь зүгээр>> гэж хэлэх юм.



SPIRITUAL JOURNEY

Байдаг л нэг энгийн зүйл мэт харагдах зүйлс нь үнэндээ үнэхээрийн эрхэм чухал гэдгийг бие сэтгэлээрээ мэдэрч, талархахын зэрэгцээ өөрийгөө сургаалийн ачаар хэдий чинээ их аврагдаж байгаагаа ойлгосон маань миний “Гайхамшиг” гэж бодож байна.

Нойрноосоо сэрж <<Ээжийн хайраар дутаж өссөн гэж бодонгоо өссөн би гэдэг хүн чин ямар гээчийн мулгуу амьтан бэ>> гэж бодогдов. Ээж минь одоо дэргэд байхгүй ч хаа нэгтээсээс үргэлж намайг харж хамгаалж байдагт сэтгэлийнхээ угаас талархаж, уярал баяслын нулимс тогтохгүй урсаж байлаа. Одоо ирж анзаарах гэж. Ээжийгээ амьд байхад нь ойлгосон бол энэ сэтгэлээ дамжуулж хэлэхсэн гэж бодогдов.

Гуравдугаарх нь би өөрийнхөө төрсөн хүү шиг л бодож явдаг хүү Косей Кайд гишүүнээр элсэж Лос- Анжелес хотноо болсон семинарт оролцохоор явсан үеийн явдал юм.

Түүнийг Лос- Анжелес хот руу явсан хойгуур санаа маань зовж огтхон ч тайвширч чадсангүй. Найзаас нь түүнийг утсаар ярьсан тухай сонсоод <<Надруу утсаар яриагүй хэрнээ>> хэмээн тунирхах сэтгэл төрөв. Сүм дээр очсон хойноо <<Яагаад надруу утсаар залгадаггүй юм бол>> гэгчлэн гомдоллов.

Тэгтэл <<Эйко гуайгийн бодсон шиг Эйко гуайг боддоггүй байж магадгүй юм. Түүний төрсөн ээж нь биш шүү дээ>> гэж хэлүүлэв.

Тэр үед ч гэсэн үнэхээр л тийм гэж бодогдоод цочих шиг болов. Хүүгээс утсаар залгалгүй удсан нь ердөө л гуравхан өдөр.

Намайг 16-тай байхад өсгөж хүмүүжүүлсэн аав маань ээжээс салсан бөгөөд түүнээс хойш өдийг хүртэл уулзах нь бүү хэл ярьдаггүй байлаа. Өсгөж хүмүүжүүлсэн ааваа аль болох өөрөөсөө түлхэж ирсэн өөртөөгөө энэ явдалаар дамжуулж анх удаа нүүр тулж чадсан юм.

<<Би гэдэг хүн үнэхээр юу хийж байсан юм бол.

Өсгөж хүмүүжүүлсэн аавдаа хичнээн их хэцүү бодол өвөрлүүлсэн юм бол>> хэмээн өөрийн үйлдэлд харамсахын зэрэгцээ хойд эцэгтээ сэтгэлийнхээ угаас талархав.

Түүнтэй зэрэгцээд мичибикидсэн хүүгээрээ дамжуулж өөрийгөө харсан тэр мөчид түүнд ч гэсэн үнэхээрийн талархаж Косей кайд хамтдаа бурханы сургаальд суралцахын гайхамшигийг мэдэрч, үгээр илэрхийлж чадамгүй их баяр баяслыг мэдрэв. Би үнэхээр аз жаргалтай хүн.

Би “Гайхамшиг” гэхээр драмын жүжиг мэт гайхалтай зүйл болдог мэтээр боддог байлаа. Гэвч энэ мэт үзэгдэлээр дамжуулж гайхамшиг гэдэг нь ямар нэг онцгой зүйлийг хэлдэггүй гэдгийг ойлгосон юм. Өдөр бүрийн байдаг л нэг амьдрал дотор байгаа бүх юмс үзэгдэл нь үнэндээ байдаг л нэг энгийн зүйл биш гэсэн бодит үнэнийг анзаарсан юм. Тийм ч болохоор байдаг л нэг энгийн зүйл мэт бодогдох зүйлс үнэндээ үнэхээрийн эрхэм чухал гэдгийг бие сэтгэлээрээ мэдэрч талархахын зэрэгцээ өөрөө өөрийгөө сургаалийн ачаар хэдий чинээ их аврагдаж байгаагаа ойлгосон явдал бол миний “Гайхамшиг” гэж бодож байна.

Өөрийнхөө өсвөр үеийн тухай бодоод үзвэл балчир байхаасаа л ганцаардалыг мэдэрч амьдарч ирснээ ойлгодог. Эцэг эх байхгүй бол үр хүүхэд ч гэсэн байхгүй. Аав ээжтэйгээ хамт амьдрах заяа байхгүй гэсэн үгүйсгэх үзэлтэй байсан намайг сүмийн гишүүд хүмүүжүүлж өгсөн юм. Би санганомын анд нараасаа хайрын гайхамшигийг хүртсээр амьдарч яваа.

Үүрэг хүлээн авах тухай яриа гарах үед ч дургүйлхэн цааргалах надад <<Эйко гуайн

SPIRITUAL JOURNEY

төлөөх зүйл болохоор хичээгээрэй>> хэмээн дэмжиж, <<Туслах болохоор>> гэж ирээд харуй бүрий болтол сууж туслана.

Сүнс шиг гишүүн байсан намайг тэвчээртэйгээр тэдоридож, Сүм рүү очих тоолонд минь инээмсэглэн угтаж, дулаахнаар хүрээлдэг. Ээж маань нөгөө ертөнц рүү явах үед, хамт уйлж, нөхрөөсөө салахад минь сэтгэлийн урам хайрлаж, хайртай нохой минь үхэхэд хамт гуниглаж өгсөн. Ханиад тусвал гэрт минь эргэхээр ирж, ажлынхаа тухай гомдол тоочиход минь чимээгүйхэн сонсож, хөгжилтэй үед минь хамт баярлаж, судар уншиж чадахгүй байна гэхээр хамтдаа уншъяа гэнэ. Үнэхээр л гараас минь хөтлөөд бурханы замаар алхаж өгдөг. Түүнчлэн сургаалийн замаас хазайхааргүйгээр удирдамж өгч зөвөлдөг. Би санга-номын анд нараасаа дээр үгүй их хайрыг хүртдэг гэдгээ ч анзаарч мэдлээ.

Надад ийм гайхалтай санга-номын анд хэмээх гэр бүл байгаагийн ачаар гэр бүлийн дулаахан илчийг мэдэрч байна. Би ганцаараа биш юм байна гэсэн амгалан сэтгэлийг мэдэрсэн маань хүн болж төрсөөр анх удаа юм. Үгээр илэрхийлж чадамгүй талархалаар сэтгэл маань бялхаж байна.

Үүнээс хойш ч гэсэн амьдралд янз бүрийн л зүйл тохиолдох байх гэж бодож байна. Гэвч сургаальд өөрийнхөө явдал мөрийг тусган харж, эрэгцүүлэн, бүх зүйлийг бурхан багшийн таалал хэмээн боддог болохын тулд өдөр бүр хичээнгүйлэн зүтгэе гэж бодож байна. Түүнчлэн ганцаараа ч болох нээ зовж шаналсан олон хүнийг аврахын тухайтад хичээеэ гэж бодлоо. Төгсгөлд нь энэ боломжоор дамжуулаад Косей Кайтай учируулж өгсөн талийгаач ээждээ болон нигүүлсэхүйн дулаахан илчээрээ түшиж тулж байдаг номын анд нартаа талархаж байгаагаа илэрхийлье. Өнөөдөр илтгэлийг минь чих тавин сонссон та бүхэнд маш их баярлалаа.



“Shanzai” сэтгүүл нь та бүхний сүсэг бишрэлийн туршлагаасаа хүүрнэсэн илтгэлийг хүлээн авсаар байна. “Shanzai” сэтгүүлд илтгэлээ хэвлүүлж, өөрийн туршлагыг дэлхий дахинтай хуваалцахгүй биз. Илтгэлээ shanzai.rk-international@kosei-kai.or.jp хаяг руу илгээнэ үү.

shanzai



Амьд биес өтөлж үхдэг



Өнгөрсөн жилд “баталгаагүй цаг үе” гэсэн үг ихэд дэлгэрсэн билээ. Энэ нь бид нарын хувьд үнэхээр хатуу жил байсан гэдгийг нотолж байгаа билээ.

Баталгаагүй цаг үе гэдэг нь нэг алхамын цаана хав харанхуй байгаатай адил өнөөгийн нийгмийн байдлыг хэлж байгаа юм. Хүмүүс итгэх зүйлгүй, санаа тайван биш учраас хазгар уруу замаар явах нь элбэг. Ийм цаг үед хүмүүс нүдний өмнө үзэгдэх бүхий зүйлд нэг баярлаж, нэг шаналж, орон гаран байдлаар амьдралаа өнгөрүүлдэг байна.

Гэвч хичнээн баталгаагүй цаг үед амьдарч байсан ч баталгаатай нэг л зүйл ямагт байдаг байна. Энэ бол амьд буй бүх амин биес хэзээ нэгэн цагт заавал өтөлж үхнэ гэсэн зүйл билээ. Үүнийг ямар ч хүн ч тойрон өнгөрч чадахгүй. Ингэж бодоход, хүний амьдрал гэдэг нь хичнээн нандин, өнгөрч буй агшин болгон хичнээн талархалтай чухал гэдгийг ойлгох болно.

Үүнийг зүрх сэтгэлдээ гүнээр сийлж, өөрийн ба бусдын амьдралыг хайрлан хүндэтгэж, энэ хорвоод хамтдаа төрж учирсан хүн болгоныг эрхэмлэн, бүх юманд нигүүлсэхүй сэтгэлээр хандсанаар амьдрал өөрчлөгдөж, “энэ хорвоод төрж амьдарсандаа баярлаж байна” гэж санагдана. Энэ баяртай сэтгэмжийг хүн болгон амсаж чадаасай гэж Будда хүсдэг байна.



Сайн зүйлс үүсч эхэлдэг

Column

Америкт ийм нэгэн үг байдгийг найз маань надад зааж өгсөн юм. “Завгүй байхдаа өдөр бүр заавал 30 минут бясалгал хийх хэрэгтэй. Харин завгүй үедээ ...нэг цаг суухгүй бол болохгүй” гэж. Та бүхэн өдөр бүр судараа хурж байгаа юу.

Энэ оны нэгдүгээр сард би Тайланд, Шириланка, Бангладешийн сүмээр зочилсон юм. Тэнд очоод сэтгэл маань ихэд хөдөлсөн зүйлийн нэг бол өөр өөрсдийн сүм дээр цуглаж ирсэн гишүүд нутгийнхаа хэлээр судраа хурж байсан явдал юм. Үнэхээр хүчтэй, нэгэн дуугаар уншиж байсан бөгөөд сургаалиас амтлах баяр хөөрөөр бялхаж байлаа. Судар хурах үйл тэнд үнэхээр бодитоор хэрэгжиж байсан. Би сэтгэлийнхээ гүнээс догдолсон.

Би ч гэсэн судар хурах үнэхээр дуртай. Судар хурж байхдаа үргэлж Шагжамуни бурханы номын хуралд суугаад сургааль сонсож байгаагаар өөрийгөө төсөөлдөг. Ертөнцийн нэгэн том амь насанд өлгийдүүлж байгаагаар мэдэрч, сэтгэл минь гүн амар амгаланг олдог. Бодисадва болж энэ хорвоод төрж ирсэн өөрийн амь насны утгыг анзаардаг. Тиймээс ирээдүй нээгдэж ирсэн мэт бодогддог.

Завгүй, эсвэл эргэн тойрны элдэв зүйлд төөрөлдөх үе. Чухам тийм үед л судар хурах учиртай юм. Тэгж гэмээнэ сэтгэл амарч сайн зүйлс үүсч эхэлдэг.

SHANZAI


Buddha's Wisdom Changes Your Life

Санал хүсэлт

“Shanzai” сэтгүүл нь та бүхний санал хүсэлтийг хүлээн авсаар байгаа. “Энэ материалыг нийтэлж өгөөч”, “Бурханы шашны ийм зүйлийг мэдмээр байна”, “Сэтгэлийг минь зовоосон ийм зүйл байна” зэрэг санал, хүсэлт, зөвлөлдөх зүйл байсан ч хүлээн авах болно. Харилцах хаяг :Энэ хуудасны доод буланд хэвлэгдсэн байгаа. Та бүхнийг олон сайхан санал, хүсэлт илгээн гэдэгт найдаж байна.

Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэгцийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашны нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



SHAN-ZAI Volume 77 (February 2012)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : shanzai@kosei-kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2012

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay
2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.rkina.org/tampabay>

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle
851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver
1571 N Race St., Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Other Groups****Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China